



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2018 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/50

Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайд, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын хамтарсан 2017 оны 12 дугаар сарын 18-ний өдрийн “Төлөвлөгөө батлах” А/515, А/204 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтад тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайд, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын хамтарсан 2017 оны 12 дугаар сарын 18-ний өдрийн “Төлөвлөгөө батлах” А/515, А/204 дугаар тушаалаар батлагдсан төсөл, арга хэмжээ XVIII.2.5 Өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 9, 19, 22 дугаар хороо/ ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, төсвийг зарцуулах эрх /гэрээ байгуулах, сунгах, цуцлах, хяналт тавих, санхүүжүүлэх/-ийг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга /Л.Төмөрбаатар/-д шилжүүлсүгэй.

2. Эрх шилжүүлсэн төсөл арга, хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журам, зааврын дагуу шуурхай зохион байгуулж, гэрээ байгуулах, ашиглалтад хүлээлгэн өгөх, хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч ажлын гүйцэтгэлийг тайлагнаж ажиллахыг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга /Л.Төмөрбаатар/-д даалгасугай.

3. Эрх шилжүүлж байгаа төсөл, арга хэмжээний захиалагчийн хяналтыг Нийслэлийн болон аймгийн холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж хэрэгжүүлэхийг “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын дарга /Ц.Амарсанаа/-т хариуцуулсугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч /Д.Ганцэцэг/-д үүрэг болгосугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ